

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт.....	15
Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ

 <b>БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	<b>ЦЭНГЭЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА К.ӨМИРГҮЛ ТАНАА</b>
<u>2024.02.09</u> № <u>74</u> танай _____ -ны № _____ -т	
<b>Өөрчлөлтгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b>	
<p>Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.</p>	
<b>Аудитын гол асуудал</b>	
<p>Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.</p>	
<b>Бусад асуудлын хэсэг</b>	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	
<p>Дүгнэлт-Цэнгэл ЭМТ 02.09 Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв</p>	

# Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Дүгнэлт-Цэнгэл ЭМТ 02.09 Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**Төгрөгөөр**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>268,371,649.80</b>	<b>170,557,785.80</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	115,439,270.00	29,578,365.26
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	115,439,270.00	29,578,365.26
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	115,439,270.00	29,578,365.26
31211	Төрийн сангийн харилцах	115,439,270.00	29,578,365.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	23,983,935.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	23,983,935.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	152,932,379.80	116,995,485.54
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	86,316,308.80	45,984,172.64
35130	Эм боох материал	86,316,308.80	45,984,172.64
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	66,616,071.00	71,011,312.90
35420	Аж ахуйн материал	58,707,812.90	65,642,112.90
35460	Хүнсний материал	7,908,258.10	5,369,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,206,106,867.54</b>	<b>1,169,011,913.27</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,206,106,867.54	1,169,011,913.27
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,194,738,867.54	1,157,643,913.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,070,709,672.98	1,117,309,672.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(137,761,380.24)	(171,351,725.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	161,619,391.00	161,619,391.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(123,608,894.60)	(135,971,892.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	307,391,855.05	333,472,055.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(120,061,698.61)	(179,930,971.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,607,361.20	99,825,361.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,404,183.24)	(67,574,721.56)
39209	Зам, гүүрийн байгууламж	246,744.00	246,744.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	880,645.00	880,645.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(880,645.00)	(880,645.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,368,000.00	11,368,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,368,000.00	11,368,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,474,478,517.34</b>	<b>1,339,569,699.07</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,474,478,517.34</b>	<b>1,339,569,699.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,474,478,517.34	1,339,569,699.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	827,213,180.00	827,213,180.00
51101	Өмч: - төрийн	827,213,180.00	827,213,180.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(116,839,519.77)	(251,748,338.04)
51210	Өмнөх үеийн үр дүн	(153,983,549.86)	(116,839,519.77)
51220	Тайлант үеийн үр дүн	37,144,030.09	(134,908,818.27)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	764,104,857.11	764,104,857.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,474,478,517.34</b>	<b>1,339,569,699.07</b>

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>586,897,562.34</b>	<b>1,440,806,053.16</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>78,283,847.34</b>	<b>12,371,885.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	23,986,977.34	12,371,885.90
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,986,977.34	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,986,977.34	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	4,580,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	7,791,585.90
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	54,296,870.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	54,296,870.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>508,613,715.00</b>	<b>1,428,434,167.26</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	320,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	320,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	55,928,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	55,928,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	508,293,715.00	1,372,506,167.26
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	508,293,715.00	1,372,506,167.26
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>549,753,532.25</b>	<b>1,575,714,871.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>549,753,532.25</b>	<b>1,575,714,871.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	549,753,532.25	1,575,082,750.43
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	306,690,434.00	821,338,397.00
210101	Үндсэн цалин	194,321,724.00	441,497,276.00
210102	Нэмэгдэл	97,626,510.00	288,613,148.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,434,500.00	11,968,000.00
210104	Урамшуулал	10,307,700.00	79,259,973.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,947,100.00	123,369,500.00
210201	Тэтгэврийн даатгал	30,564,000.00	83,891,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,595,700.00	9,869,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,876,700.00	7,895,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	719,100.00	1,973,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,191,600.00	19,739,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	49,690,279.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,926,017.00
210302	Түлш, халаалт	-	41,764,262.00
210303	Цэвэр, бохир ус	-	3,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,260,040.00	132,662,999.00
210401	Бичиг хэрэг	1,159,850.00	6,783,050.00
210402	Тээвэр, шатахуун	33,892,790.00	96,866,249.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	710,000.00	2,050,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,194,400.00	7,409,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,303,000.00	19,553,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	71,879,174.73	300,538,895.16

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,336,024.73	228,521,687.06
210502	Хоол, хүнс	13,261,450.00	60,110,358.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,281,700.00	11,906,850.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,041,700.00</b>	<b>8,658,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,615,000.00	-
210604	Урсгал засвар	1,426,700.00	8,658,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>644,000.00</b>	<b>2,620,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	644,000.00	2,620,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,442,675.00</b>	<b>4,905,200.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	449,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,675.00	3,285,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1,121,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>78,848,408.52</b>	<b>131,298,580.27</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,121,925.00	11,305,426.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,726,483.52	119,993,154.27
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>632,121.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>632,121.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	632,121.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>37,144,030.09</b>	<b>(134,908,818.27)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>37,144,030.09</b>	<b>(134,908,818.27)</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,331,543,415.00</b>	<b>1,404,450,232.26</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,331,543,415.00</b>	<b>1,404,450,232.26</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,481,160.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	320,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,161,160.00	
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	44,840,400.00	55,928,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,840,400.00	55,928,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,285,221,855.00	1,348,522,232.26
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,285,221,855.00	1,348,522,232.26
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,196,336,439.00</b>	<b>1,411,993,237.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,196,336,439.00</b>	<b>1,411,993,237.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,196,125,453.00</b>	<b>1,411,361,116.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	634,872,683.00	821,338,397.00
210101	Үндсэн цалин	377,833,764.00	441,497,276.00
210102	Нэмэгдэл	205,586,290.00	288,613,148.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,434,500.00	11,968,000.00
210104	Урамшуулал	47,018,129.00	79,259,973.00

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	145,873,200.00	123,369,500.00
210201	Тэтгэврийн даатгал	115,755,500.00	83,891,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,529,400.00	9,869,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,023,400.00	7,895,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,506,000.00	1,973,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,058,900.00	19,739,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,221,414.00	50,690,279.00
210301	Гэрэл, цахилгаан	4,761,444.00	4,926,017.00
210302	Түлш, халаалт	32,459,970.00	41,764,262.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	4,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	92,705,975.00	132,569,849.00
210401	Бичиг хэрэг	5,651,800.00	7,199,000.00
210402	Тээвэр, шатахуун	69,586,275.00	96,866,249.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,210,000.00	2,050,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,571,000.00	7,398,625.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,686,900.00	19,055,575.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	207,201,981.00	248,737,365.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,054,281.00	181,493,965.00
210502	Хоол, хүнс	52,191,200.00	55,854,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,956,500.00	11,388,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,165,000.00	12,271,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,385,000.00	925,000.00
210602	Тавилга		710,000.00
210604	Урсгал засвар	7,780,000.00	10,636,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,694,000.00	2,620,000.00
210702	Дотоод албан томилолт	1,694,000.00	2,620,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,346,175.00	4,909,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	449,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,733,575.00	3,285,100.00
210807	Газрын төлбөр	120,800.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	161,800.00	1,125,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	44,045,025.00	14,854,926.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,045,025.00	14,854,926.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>210,986.00</b>	<b>632,121.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	210,986.00	632,121.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	210,986.00	632,121.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>135,206,976.00</b>	<b>(7,543,004.74)</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>21,397,900.00</b>	<b>78,317,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,397,900.00</b>	<b>78,317,900.00</b>

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	21,397,900.00	78,317,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,397,900.00	78,317,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(21,397,900.00)</b>	<b>(78,317,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	113,809,076.00	(85,860,904.74)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,630,194.00	115,439,270.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	115,439,270.00	29,578,365.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	827,213,180.00	764,104,857.11	-153,983,549.86	1,437,334,487.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	827,213,180.00	764,104,857.11	-153,983,549.86	1,437,334,487.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			37,144,030.09	37,144,030.09
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	827,213,180.00	764,104,857.11	-116,839,519.77	1,474,478,517.34
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	827,213,180.00	764,104,857.11	-116,839,519.77	1,474,478,517.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	827,213,180.00	764,104,857.11	-116,839,519.77	1,474,478,517.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-134,908,818.27	-134,908,818.27

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	827,213,180.00	764,104,857.11	-251,748,338.04	1,339,569,699.07
-----	---------------------------------------	----------------	----------------	-----------------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	115,439,270.00	115,439,270.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,653,969,900.00	1,489,679,016.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,653,969,900.00	1,489,679,016.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,653,969,900.00	1,489,679,016.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	981,485,300.00	821,338,397.00
210101	Үндсэн цалин	526,152,800.00	441,497,276.00
210102	Нэмэгдэл	355,938,600.00	288,613,148.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,712,000.00	11,968,000.00
210104	Урамшуулал	90,681,900.00	79,259,973.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	123,369,500.00	123,369,500.00
210201	Тэтгэврийн даатгал	83,891,500.00	83,891,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,869,600.00	9,869,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,895,500.00	7,895,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,973,800.00	1,973,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,739,100.00	19,739,100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,321,700.00	50,690,279.00
210301	Гэрэл, цахилгаан	5,537,200.00	4,926,017.00
210302	Түлш, халаалт	42,784,500.00	41,764,262.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	4,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	136,853,900.00	133,961,675.00
210401	Бичиг хэрэг	7,199,000.00	7,199,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,796,100.00	96,866,249.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,026,200.00	2,050,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,125,400.00	8,094,651.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,707,200.00	19,751,375.00
2105	<b>Нормативт зардал</b>	248,846,300.00	248,737,365.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	181,499,600.00	181,493,965.00
210502	Хоол, хүнс	55,858,200.00	55,854,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,488,500.00	11,388,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	73,045,500.00	73,012,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,939,200.00	16,939,200.00
210602	Тавилга	10,000,000.00	9,968,000.00
210604	Урсгал засвар	46,106,300.00	46,105,300.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,625,300.00	2,620,000.00
210702	Дотоод албан томилолт	2,625,300.00	2,620,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,382,200.00	4,909,100.00

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	449,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,286,800.00	3,285,100.00
210807	Газрын төлбөр	120,400.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,125,000.00	1,125,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,040,200.00</b>	<b>31,040,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,040,200.00	31,040,200.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,538,530,700.00</b>	<b>1,403,818,111.26</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>55,928,000.00</b>	<b>55,295,879.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	55,928,000.00	55,295,879.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,482,602,700.00</b>	<b>1,348,522,232.26</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,482,602,700.00	1,348,522,232.26
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>115,439,270.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>29,578,365.26</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>44</b>	<b>44</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	36	36
620003	Үйлчлэх ажилтан	7	7
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>44</b>	<b>44</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	37	37
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм. Тайлант онд "Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн чанартай тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй, аюулгүй орчинд мэргэжилтний ёс зүй, өндөр мэдлэг, ур чадвартай багаар үзүүлнэ." гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

## Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд 2023 онд аймгийн ЭМГ-аас шалгалт хийж, шалгалтын дүнгээр зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 29 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134.9 сая төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	115,439.3	29,578.4	-85,860.9
Авлага	0.0	23,983.9	23,983.9
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	152,932.4	116,995.5	-35,936.9
Үндсэн хөрөнгө	1,206,106.9	1,169,011.9	-37,095.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,474,478.5</b>	<b>1,339,569.7</b>	<b>-134,908.8</b>

## Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,474,478.5	1,339,569.7	-134,908.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,474,478.5</b>	<b>1,339,569.7</b>	<b>-134,908.8</b>

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 29.6 сая төгрөг болж 85.9 сая төгрөгөөр буурсан байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд 23.9 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 116.9 сая төгрөг болж оны эхнээс 35.9 сая төгрөгөөр буурсан байна. Эм боох материалын үлдэгдэл 45.9 сая, аж ахуйн материал 65.6 сая, хүнсний материалын үлдэгдэл 5.3 сая төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр 399.8 сая төгрөгийн материал худалдан авч, үнэ төлбөргүй 7.8 сая төгрөгийн бараа материал авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,169.0 сая төгрөг болж 37.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 78.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 4.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 134.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -134.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 1,542.8 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 1,486.9 сая, орон нутгийн төсвөөс 55.9 сая, нийт 1,542.8 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 111.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,653.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 218.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 27.6 сая, үйлчилгээний бусад зардлыг 26.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 35.6 сая, нормативт зардлыг 51.9 сая, эд хогшил, урсгал засварыг 65.4 сая, томилолтын зардлыг 3.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 0.8 сая төгрөгөөр бууруулж, нийт 111.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 1,482.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 55.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, 15.4 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,348.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 55.3 сая төгрөг оруулж, оны эхний үлдэгдлээс 85.9 сая төгрөгийг зарцуулж, нийт 1,489.7 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,489.7 сая төгрөг буюу 90 хувьтай байна. Энэ нь эрүүл мэндийн даатгалын сангаас төлөвлөснөөс 134.1 сая төгрөгөөр бага санхүүжилт авсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

## Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1	Нэг иргэнд ногдох нормативаар	1,047.4	916.3	-131.1	88%
2	Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ	435.2	432.2	-3.0	100%
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан	115.4	85.8	0.00	75%
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	55.9	55.3	-0.3	99%
	<b>Дүн</b>	<b>1,653.9</b>	<b>1,489.7</b>	<b>164.2</b>	<b>90%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн төв нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 399.8 сая төгрөгийн бараа материал, 78.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

## Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,220.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгаж тэтгэмж давхардуулсан олгосон зөрчилд албан шаардлага өгөгдсөн.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд төсөв өмч, хөрөнгө зарцуулах 57.8 сая төгрөгийн 4 шийдвэр, авлага үүсгэсэн 23.9 сая төгрөгийн 1 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байна. Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Алдаа зөрчил илрээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 21,397.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төрийн цахим худалдан авалтын тухай хууль тогтоомжийг зөрчиж худалдан авсан зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					

## Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Албан шаардлага	1	21,397.9	0	0	0%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>21,397.9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>

Тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул төсвийн захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт 0.6 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг оруулж тайлагнасныг залруулав.

Аудитаар нийтдээ 104.0 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 22.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 81.8 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад илэрсэн зөрчлийн дүнгээр 22.2 сая төгрөгийн албан шаардлагуудыг өгсөн.

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж тайлант онд 18.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрт бүртгэлгүй аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдаж авсан.

#### Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй Эрүүл мэндийн төвийн даргад сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг ирүүлэх талаар албан шаардлага өгөв.

2. Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнуудад 3.4 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон.

#### Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг баримталж тэтгэвэрт гарсан ажилтнуудад төсвөөс давхардуулж илүү тэтгэмж олгохгүй байх, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Төсөв өмч, хөрөнгө зарцуулах 57.8 сая төгрөгийн 4 шийдвэр, авлага үүсгэсэн 23.9 сая төгрөгийн 1 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “..... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### 2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлээгүй төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, авлага үүсгэсэн 81.7 сая төгрөгийн 5 шийдвэрийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТ-ийн эх үүсвэрт төвлөрүүлсэн шилжүүлгийг оруулж тайлагнасан.	1	632.1			1	632.1	1	632.1				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>632.1</b>			<b>1</b>	<b>632.1</b>	<b>1</b>	<b>632.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах авлага үүсгэсэн 81.7 сая төгрөгийн 5 шийдвэрийг байршуулаагүй	1	81,783.9					1	81,783.9
Дүн	1	81,783.9					1	81,783.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тэтгэвэрт гарсан ажилтнуудад давхардуулж тэтгэмж олгосон.	1	3,432.4			1	3,432.4		
Өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	18,799.0			1	18,799.0		
Дүн	2	22,231.4			2	22,231.4		
Нийт дүн	3	104,015.3			3	104,015.3		